

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Эрдэнэт хотын захирагчийн албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/27/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэт хот 2024 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: <a href="mailto:narmandakhts@audit.gov.mn">narmandakhts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: <a href="mailto:buyanundrakhb@audit.gov.mn">buyanundrakhb@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Бямбатогтох Утас: 70357955 Цахим хаяг: <a href="mailto:byambatogtokhb@audit.gov.mn">byambatogtokhb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 82

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
АЛБАНЫ ДАРГА Б.ОДГЭРЭЛ  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэт хотын захирагчийн албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэт хотын захирагчийн албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэт хотын захирагчийн алба нь 2023 оны үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлж, батлагдсан төсвийг 0.4 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 99.6 хувьтай тайлагнасан байна.

#### Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/734 дүгээр захирамжаар Баян-Өндөр сумын хэмжээнд 2023 оны 7, 8, 9 дүгээр саруудад орсон усархаг борооны улмаас хотын доторх хатуу хучилттай авто замуудад суулт ихээр үүсэж, эвдрэл гарсан мөн гэр хорооллын хайрган хучилттай авто замуудад шавар ихээр тогтож, авто машин явахад хүндрэл үүссэн талаар иргэдээс гомдол, санал, хүсэлт ихээр ирж байгаа тул засварын ажилд шаардагдах хөрөнгөд нийт 101.9 сая төгрөгийг баталж, тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлж, 62.7 сая төгрөгийг авто замын нөхөөс хийсэн аж ахуй нэгж рүү, 39.2 сая төгрөгийн шатахууныг Баян-Өндөр сумын багуудад олгож, зарцуулсан байна.

D:\my doc\alban bichig\2024-A4.doc

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг 95.1 хувьтай үнэлсэн байна.

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,848,364.82</u></b>	<b><u>20,315,394.68</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	168,299.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	168,299.86
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15,848,364.82	20,147,094.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	860,200.00	467,000.00
35110	Тусгай зориулалттай материал	860,200.00	467,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,097,670.00	4,830,770.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,890,494.82	14,849,324.82
35410	Бичиг хэргийн материал	842,600.00	1,407,100.00
35420	Аж ахуйн материал	9,158,695.00	11,083,245.00
35430	Сэлбэг хэрэгсэл	825,000.00	825,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,199.82	1,533,979.82
35470	Бусад хангамжийн материал	60,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>171,911,414.25</u></b>	<b><u>109,295,214.84</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	171,911,414.25	109,295,214.84
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	113,648,914.27	81,617,714.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,000,000.00	78,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,000,000.00)	(77,270,833.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,176,530.00	143,076,430.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,188,072.59)	(74,996,453.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,386,246.40	21,386,246.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,725,789.54)	(9,077,674.82)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	58,262,499.98	27,677,500.01
39301	Програм хангамж	73,438,000.00	93,238,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,175,500.02)	(65,560,499.99)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>187,759,779.07</u></b>	<b><u>129,610,609.52</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>187,759,779.07</u></b>	<b><u>129,610,609.52</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	187,759,779.07	129,610,609.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	53,946,544.97	53,946,544.97
51101	Өмч: - төрийн	53,946,544.97	53,946,544.97
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	132,896,639.51	74,747,469.96
51210	Өмнөх үеийн үр дүн	132,896,639.51	132,896,639.51
51220	Тайлант үеийн үр дүн	-	(58,149,169.55)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	916,594.59	916,594.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>187,759,779.07</u></b>	<b><u>129,610,609.52</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>396,710,600.00</b>	<b>591,678,009.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>131,642,800.00</b>	-
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	131,642,800.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	131,427,800.00	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал	215,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>265,067,800.00</b>	<b>591,678,009.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,800,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,800,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	236,267,800.00	591,678,009.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	236,267,800.00	462,619,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	129,059,009.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>268,687,395.33</b>	<b>656,559,225.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>268,687,395.33</b>	<b>656,559,225.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	266,095,920.82	620,678,540.07
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,221,655.87	306,100,432.05
210101	Үндсэн цалин	119,609,147.17	175,765,370.38
210102	Нэмэгдэл	37,645,675.70	94,658,058.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,179,133.00	13,495,500.00
210104	Урамшуулал	787,700.00	22,181,503.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,754,676.01	40,043,314.15
210201	Тэтгэврийн даатгал	15,862,184.25	27,635,933.04
210202	Тэтгэмжийн даатгал	1,878,739.27	3,239,226.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,398,830.17	2,454,981.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,285,240.22	610,287.46
210205	Эрүүл мэндийн даатгал	3,329,682.10	6,102,885.83
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,745,105.61	78,331,811.30
210401	Бичиг хэрэг	11,759,200.00	20,426,300.00
210402	Тээвэр, шатахуун	11,660,600.00	53,717,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,325,305.61	1,597,881.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	165,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,425,450.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,579,000.00	174,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,579,000.00	174,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,824,000.00	64,508,549.00
210604	Урсгал засвар	1,824,000.00	64,508,549.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,877,400.00	5,960,100.00
210702	Дотоод албан томилолт	1,877,400.00	5,960,100.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,089,488.00	36,327,167.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	28,746,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,800,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,578.00	56,577.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,112,900.00	7,425,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,004,595.33	89,232,766.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,004,595.33	89,232,766.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,591,474.51	35,880,685.14
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,000,000.00	32,721,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,721,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	591,474.51	3,159,185.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	591,474.51	3,159,185.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>128,023,204.67</b>	<b>(64,881,216.21)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	0.40	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.40	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(0.40)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>128,023,204.27</b>	<b>(64,881,216.21)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>265,067,800.00</b>	<b>591,678,009.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>265,067,800.00</b>	<b>591,678,009.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,800,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,800,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	236,267,800.00	591,678,009.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	236,267,800.00	462,619,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	129,059,009.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>242,067,800.00</b>	<b>569,978,109.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>242,067,800.00</b>	<b>569,978,109.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>239,476,325.49</b>	<b>534,097,423.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,221,655.87	306,046,412.97
210101	Үндсэн цалин	119,609,147.17	167,814,535.17

210102	Нэмэгдэл	37,645,675.70	102,059,226.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,179,133.00	14,828,938.61
210104	Урамшуулал	787,700.00	21,343,712.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,754,676.01</b>	<b>40,265,633.09</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,862,184.25	28,101,981.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,878,739.27	3,186,543.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,398,830.17	2,404,034.78
210204	Ажилгүйдлийн даатгал	1,285,240.22	597,551.83
210205	Эрүүл мэндийн даатгал	3,329,682.10	5,975,521.42
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,530,105.61</b>	<b>76,185,761.30</b>
210401	Бичиг хэрэг	11,759,200.00	20,967,300.00
210402	Тээвэр, шатахуун	11,445,600.00	53,431,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,325,305.61	1,525,881.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	261,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,579,000.00</b>	<b>378,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,579,000.00	378,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,824,000.00</b>	<b>64,508,549.00</b>
210604	Урсгал засвар	1,824,000.00	64,508,549.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,877,400.00</b>	<b>5,960,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,877,400.00	5,960,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,689,488.00</b>	<b>40,752,967.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	33,150,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,800,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,578.00	56,577.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,712,900.00	7,425,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,591,474.51</b>	<b>35,880,685.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>32,721,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,721,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>591,474.51</b>	<b>3,159,185.14</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	591,474.51	3,159,185.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>23,000,000.00</b>	<b>21,699,900.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>23,000,000.00</b>	<b>21,699,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>23,000,000.00</b>	<b>21,699,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>23,000,000.00</b>	<b>21,699,900.00</b>
223001	Бусад хөрөнгө	23,000,000.00	21,699,900.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(23,000,000.00)	(21,699,900.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,946,544.97	916,594.59	132,896,639.51	187,759,779.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,946,544.97	916,594.59	132,896,639.51	187,759,779.07
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,946,544.97	916,594.59	132,896,639.51	187,759,779.07
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	53,946,544.97	916,594.59	132,896,639.51	187,759,779.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,946,544.97	916,594.59	132,896,639.51	187,759,779.07
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(58,149,169.55)	(58,149,169.55)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,946,544.97	916,594.59	74,747,469.96	129,610,609.52

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,267,800.00	235,676,325.49	462,619,000.00	459,459,814.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,267,800.00	235,676,325.49	462,619,000.00	437,759,914.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,267,800.00	233,676,325.49	429,897,500.00	405,038,414.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,572,200.00	172,221,655.87	306,047,100.00	306,046,412.97
210101	Үндсэн цалин	123,163,100.00	119,609,147.17	161,438,700.00	167,814,535.17
210102	Нэмэгдэл	42453900.00	37645675.70	101189000.00	102,059,226.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,955,200.00	14,179,133.00	17,160,000.00	14,828,938.61
210104	Урамшуулал	0.00	787700.00	26259400.00	21343712.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,297,200.00	23,754,676.01	41,308,100.00	40,265,633.09
210201	Тэтгэврийн даатгал	16,394,400.00	15,862,184.25	28,544,200.00	28,101,981.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,725,700.00	1,878,739.27	3,358,000.00	3,186,543.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,380,600.00	1,398,830.17	2,310,200.00	2,404,034.78

210204	Ажилгүйдлийн даатгал	345,100.00	1,285,240.22	644,800.00	597,551.83
210205	Эрүүл мэндийн даатгал	3451400.00	3329682.10	6450900.00	5975521.42
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,430,600.00	24,530,105.61	24,824,800.00	24,824,781.30
210401	Бичиг хэрэг	11,759,200.00	11,759,200.00	11,759,200.00	11,667,300.00
210402	Тээвэр, шатахуун	11,445,600.00	11,445,600.00	11,445,600.00	11,445,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,800.00	1,325,305.61	1,620,000.00	1,525,881.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	-	186,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,580,000.00	1,579,000.00	1,580,000.00	378,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,580,000.00	1,579,000.00	1,580,000.00	378,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,826,000.00	1,824,000.00	1,826,000.00	1,826,000.00
210604	Урсгал засвар	1,826,000.00	1,824,000.00	1,826,000.00	1,826,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,000,000.00	1,877,400.00	6,143,900.00	5,960,100.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,877,400.00	6,143,900.00	5,960,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,561,800.00	7,889,488.00	48,167,600.00	25,737,487.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	40,000,000.00	18,135,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	117,700.00	98,010.00	117,700.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,200.00	56,578.00	59,200.00	56,577.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,822,900.00	7,712,900.00	7,428,700.00	7,425,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,000,000.00	2,000,000.00	32,721,500.00	32,721,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,000,000.00	2,000,000.00	32,721,500.00	32,721,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	30,721,500.00	30,721,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	<b>21,699,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-	-	21,699,900.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	21,699,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	236,267,800.00	235,676,325.49	462,619,000.00	459,459,814.86
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	236,267,800.00	235,676,325.49	462,619,000.00	459,459,814.86
132001	Орон нутгийн төсвөөс	236,267,800.00	235,676,325.49	462,619,000.00	459,459,814.86
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>			-	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>13.00</b>	<b>13.00</b>	<b>13.00</b>	<b>12.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	4.00	4.00	4.00	3.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	9.00	9.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>28,800,000.00</b>	<b>129,059,009.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,800,000.00</b>	<b>129,059,009.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,800,000.00	129,059,009.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	51,360,980.00
210401	Бичиг хэрэг		9,300,000.00
210402	Тээвэр, шатахуун		41,985,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		75,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	62,682,549.00
210604	Урсгал засвар		62,682,549.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,800,000.00	15,015,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		15,015,480.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,800,000.00	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>23,000,000.00</b>	-
2200	Дотоод эх үүсвэрээр	23,000,000.00	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,000,000.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	28,800,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,800,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,800,000.00	

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,837.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 3,837.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж тайлагналаа.

#### Залруулсан алдаа:

- Машин,тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, программ хангамжийн тайлант оны хуримтлагдсан элэгдлийг 3,837.4 мянган төгрөгөөр дутуу тооцсоныг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 2,115.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,115.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах 6 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Байгууллагын дарга тушаал шийдвэргүй 401.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 359.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс авсан, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа эдэлж чадаагүй нь нотлогдохгүй, ээлжийн амралт биеэр эдэлж чадаагүй

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэмэгдэл 1,355.2 мянган төгрөг олгосон тул нийт 2,115.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй болно.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн цалингийн ангилал, зэрэглэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Албаны даргын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар мэргэжилтнүүдийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлээр /ТҮ-7/ тогтоож, цалин хөлсийг шинэчлэн баталжээ. Энэ нь Төрийн албаны тухай хууль 12.1-д "Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна", Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-д "Улсын зэрэглэлтэй хотын захирагчийн албаны мэргэжилтэн" нь ТЗ-8 албан тушаалын зэрэглэлд, дэс түшмэлийн албан тушаалын ангилалд хамаарах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Мэргэжилтнүүдийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох.

2. Албан хаагчийн цагийн бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Илүү цагаар ажилласан хөлс олгохдоо албан хаагч өөрсдөө гараар бүртгэдэг бүртгэлийг үндэслэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Албан хаагчдын цагийн бүртгэлийг цахимжуулж, цахим цагийн бүртгэлийг үндэслэн илүү цаг, цалин хөлс олгож байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6 дах хэсэг 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

#### 4. Бараа материалын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шатах, тослох материалыг зарцуулахдаа шаардах хуудас хөтөлдөггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3 дах хэсгийн 6-д "НХМаягт БМ-6 Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шатах тослох материалыг зарцуулахдаа шаардах хуудсыг үндэслэж, анхан шатны баримтын бүрдлийг хангах.

#### 5. Бараа материалын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тусгай зориулалтын материал болон аж ахуйн материалыг тушаал шийдвэргүй данснаас хассан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4.5-д "Эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тусгай зориулалтын материал, аж ахуйн материалыг данснаас хасахдаа тооллогын комиссын санал болон өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэх.

#### 6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Төсөв, хөрөнгө зарцуулах, үндсэн хөрөнгө орлогод авах, хөрөнгө данснаас хасахтай холбоотой 51,199.9 мянган төгрөгийн 3 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэт хотын захирагчийн алба	1	3,837.4	1	3,837.4			1	3,837.4	1			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,837.4</b>	<b>1</b>	<b>3,837.4</b>			<b>1</b>	<b>3,837.4</b>	<b>1</b>			

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэт хотын захирагчийн алба	8	2,115.9	3	2,115.9			5	-				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>2,115.9</b>	<b>3</b>	<b>2,115.9</b>			<b>5</b>	<b>-</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс			
							Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Эрдэнэт хотын захирагчийн алба	1	-							1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>							<b>1</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			